

## **ҮНЭТ ЦААС ЗЭЭЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэ журмаар үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг хэрэгжүүлэхэд тавигдах шаардлага, зээлдүүлж болох үнэт цаасны төрөл, гэрээний нөхцөл, барьцаа хөрөнгийн удирдлага, тусгаарлалт, оролцогч талуудын эрх, үүрэг, мэдээллийн ил тод байдалтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Энэ журмын харилцаанд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон Хорооны баталсан холбогдох журмыг дагаж мөрдөнө.
- 1.3. Энэ журмаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зохицуулалтад хамрагдаагүй хязгаарлагдмал хариуцлагатай компани, хаалттай хувьцаат компанийн үнэт цаас, зохицуулалттай зах зээлд арилжаалахыг зөвшөөрөөгүй бусад төрлийн үнэт цаасыг зээлэх, зээлдүүлэх, барьцаалахтай холбоотой харилцааг зохицуулахгүй.

### **ХОЁР. ҮНЭТ ЦААС ЗЭЭЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН ЗЭЭЛДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ ҮНЭТ ЦААС**

- 2.1. Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээнд зээлдэгч болон зээлдүүлэгч нь дараах этгээдүүд оролцоно. Үүнд:
  - 2.1.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.19-т заасан хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк, хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн сан, банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаа, даатгал, дилерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд болон Хорооноос мэргэжлийн хөрөнгө оруулагч гэж тогтоосон бусад этгээд;
  - 2.1.2. Иргэн;
- 2.2. Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээнд дараах этгээд зуучлагийн үйл ажиллагаа эрхлэх этгээд (цаашид “зуучлагч” гэх)-ээр оролцоно. Үүнд:
  - 2.2.1. Кастодианы үйл ажиллагаа эрхлэгч этгээд (цаашид “Кастодиан” гэх);
  - 2.2.2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага (цаашид “ҮЦТХТ” гэх);
  - 2.2.3. Үнэт цаасны компани (цаашид “ҮЦК” гэх).
- 2.3. Энэ журмын 2.1.1-т заасан хөрөнгө оруулалтын сан нь хамтын сан хэлбэртэй байх бөгөөд үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээнд зөвхөн энэ журмын 2.2.1-т заасан этгээдээр дамжуулан оролцоно.
- 2.4. Энэ журмын 2.1-т заасан этгээдийн зээлдүүлж болох үнэт цаасны хэмжээ нь нийт эзэмшиж буй үнэт цаасны дараах хэмжээнээс хэтрэхгүй байна. Үүнд:
  - 2.4.1. хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хувьд 25 хувь;
  - 2.4.2. хөрөнгө оруулалтын сангийн хувьд 30 хувь;
  - 2.4.3. тэтгэврийн сангийн хувьд 10 хувь;
  - 2.4.4. төв банкны хувьд 100 хувь;

- 2.4.5. арилжааны банкны хувьд 20 хувь;
  - 2.4.6. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувьд 10 хувь;
  - 2.4.7. даатгалын компанийн хувьд 7 хувь;
  - 2.4.8. дилерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувьд 30 хувь;
  - 2.4.9. иргэний хувьд 10 хувь.
- 2.5. Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээнд дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь өөрийн нэр дээрх үнэт цаасыг харилцагчид зээлдүүлэх тохиолдолд мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номинал дансны эрхтэй байх бөгөөд энэ тохиолдолд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын төвлөрсөн бүртгэлд өөрчлөлт оруулахгүй байж болно.
- 2.6. Энэ журмын 2.5-т заасан этгээд нь хөрөнгө оруулалтын сангаас бусад зээлдэгчдэд энэ журмын 2.2-т заасан этгээдээр дамжуулахгүйгээр шууд зээлдүүлж болно.
- 2.7. Энэ журмын 2.1.2-т заасан этгээд нь сүүлийн 1 жилийн турш дотоод, гадаадын зах зээл дээр үнэт цаасны арилжаанд оролцсон туршлагатай байх бөгөөд үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээнд заавал зуучлагчаар дамжуулан оролцоно.
- 2.8. Зээлдүүлэгч нь нээлттэй арилжаалагддаг Засгийн газар, аймаг, нийслэлийн үнэт цаас, олон улсын санхүүгийн байгууллагын бонд, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын I, II, III ангилалд бүртгэлтэй компанийн хувьцаа, компанийн бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хамтын хаалттай сангийн нэгж эрх, үнэт цаасны зах зээлд арилжаалахаар гаргасан хадгаламжийн сертификатаас бусад үнэт цаасыг зээлдүүлэхгүй.

## ГУРАВ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

- 3.1. Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээнд оролцож буй талууд хооронд “Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх гэрээ” (цаашид “гэрээ” гэх)-г Олон улсын үнэт цаас зээлдүүлэх холбоо (ISLA)-ны зарчмуудад тулгуурлан харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулах бөгөөд уг гэрээнд дараах зүйлсийг тусгана:
- 3.1.1. талуудын хууль ёсны нэр, хаяг, иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар болон бусад шаардлагатай мэдээлэл;
  - 3.1.2. зээлдүүлэх үнэт цаасны төрөл, тоо хэмжээ, төрөл тус бүрийн болон нийт үнийн дүн;
  - 3.1.3. зээлийн хугацаа;
  - 3.1.4. барьцаа хөрөнгийн болон барьцаа хөрөнгө үнэт цаас байх тохиолдолд хорогдуулалтын хувь;
  - 3.1.5. үйлчилгээний шимтгэлийн хувь хэмжээ, төлөх давтамж, тооцож эхлэх хугацаа;
  - 3.1.6. барьцаанд тавьсан мөнгөн хөрөнгийг хадгаламжид байршуулах тохиолдолд хүү тооцож эхлэх болон дуусах өдөр;
  - 3.1.7. талуудын эрх, үүрэг, хариуцлага;
  - 3.1.8. гэрээний зөрчил үүсэх нөхцөл, үүссэн тохиолдолд авах арга хэмжээ;
  - 3.1.9. бусад.
- 3.2. Гэрээ байгуулахаас өмнө зээлдэгчийг таньж мэдэх, түүний санхүүгийн чадамж, барьцаа хөрөнгө, хөрөнгө оруулалтын туршлагыг хянаж үзсэний үндсэн дээр үнэт цаас зээлдүүлэх эсэх шийдвэрийг гаргана.

- 3.3. Үнэт цаас зээлж авах хүсэлт гаргасан этгээдтэй гэрээ байгуулахаас өмнө зуучлагч, эсхүл зээлдүүлэгч нь үнэт цаас зээлэх болон зээлдүүлэхтэй холбогдон үүсэж болзошгүй эрсдэлийн тухай мэдээллийг холбогдох талуудад танилцуулсан байна.
- 3.4. Зээлдүүлэгч зээлдүүлэх үнэт цаасыг зээлдэгчид шилжүүлж, зээлдэгч барьцааг зээлдүүлэгчид шилжүүлсэн тохиолдолд гэрээ хүчин төгөлдөр болно.
- 3.5. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эсхүл аль нэг талын санаачилгаар, талууд зөвшилцөлд хүрснээр цуцалж болно.
- 3.6. Зээлдүүлсэн үнэт цаасны ногдол ашиг, үнэт цаасны хүү болон саналын эрх зэрэг үнэт цаасны эзэмшилтэй холбоотой тухайн үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх эрх гэрээний хугацаанд зээлдэгчид шилжих бөгөөд зээлдэгч нь тухайн өгөөжийг талуудын гэрээгээр тохиролцсон хугацаанд зээлдүүлэгчид олгоно.
- 3.7. Талууд гэрээнд өөрөөр тохиролцоогүй бол зээлдэгч нь зээлсэн үнэт цаастай холбоотой аливаа шимтгэл, хураамж болон бусад холбогдох зардлыг хариуцах бөгөөд зээлдүүлэгч нь барьцаа хөрөнгөтэй холбогдох зардлыг хариуцна.

### **ДӨРӨВ. БАРЬЦАА ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА**

- 4.1. Зээлдэгч нь зээлж авах үнэт цаасны зах зээлийн ханшинд суурилан үнэт цаасыг эргэн төлөх баталгаа болгон барьцаа хөрөнгийг байршуулах бөгөөд барьцаа хөрөнгө нь бэлэн мөнгө, эсхүл нээлттэй арилжаалагддаг Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргаас гаргасан үнэт цаас, олон улсын санхүүгийн байгууллагаас гаргасан өрийн хэрэгсэл, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын I ангилалд бүртгэлтэй компанийн хувьцаа, компанийн бонд, үнэт цаасны зах зээлд арилжаалахаар гаргасан хадгаламжийн сертификат, эсхүл аккредитивээс бүрдэнэ.
- 4.2. Энэ журмын 4.1-т заасан барьцаа хөрөнгө нь мөнгөн эсхүл аккредитив хэлбэртэй байх тохиолдолд зээлж авах үнэт цаасны зах зээлийн ханштай тэнцүү, эсхүл үнэт цаас хэлбэртэй байх тохиолдолд зээлж авах үнэт цаасны зах зээлийн ханшнаас дээш дүнтэй байх бөгөөд энэ тохиолдолд хорогдуулалтын хувь хэмжээг гэрээнд тусгана.
- 4.3. Зээлдэгч болон зээлдүүлэгч хоорондоо тохиролцсон бол зээлдэгч нь зээлээр авсан үнэт цаасаа буцаан олгох хүртэл зээлдүүлэгч нь барьцаанд байгаа бэлэн мөнгийг арилжааны банкны тусгайлан нээсэн харилцах эсхүл мөнгөн хадгаламжид тусад нь хадгалуулах бөгөөд мөнгөн хадгаламжид хадгалуулах тохиолдолд хадгаламжийн хүүгийн орлогын хэмжээ, төлбөрийн нөхцөлийг талууд тохиролцсоны үндсэн дээр гэрээнд тодорхой заана.
- 4.4. Зээлдүүлэгч нь зээлдүүлэх үнэт цаасны зах зээлийн ханшинд үндэслэн барьцаа хөрөнгийн үнэлгээг өдөр тутам тооцох бөгөөд гэрээнд заасан хуваарийн дагуу дутагдал гарсан тохиолдолд нэмэлт барьцаа байршуулахыг зээлдэгчээс шаардах, илүүдэл гарсан бол илүү хэсгийг зээлдэгчид буцаан шилжүүлнэ.
- 4.5. Зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд зээлдүүлэгч нь барьцаа хөрөнгийг зарж борлуулах, түүнээс олсон орлогыг зээлдүүлсэн үнэт цаасыг дахин худалдан авах болон зээлдэгчээс төлөгдөх ёстой бусад төлбөр, хураамжийг барагдуулахад ашиглана.
- 4.6. Энэ журмын 4.5-т заасны дагуу зээлдүүлсэн үнэт цаасыг дахин худалдан авах тохиолдолд гарах зардал нь барьцаа хөрөнгийн ханшнаас давсан бол зээлдэгч зөрүү төлбөрийг төлөх бөгөөд бүх төлбөр, үүргийг бүрэн барагдуулсны дараа үлдэгдэл барьцаа хөрөнгийг зээлдэгчид буцаан олгоно.

### **ТАВ. БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ТУСГААРЛАХ, ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, ТУСГААРЛАЛТААС ЧӨЛӨӨЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 5.1. Үнэт цаас хэлбэртэй барьцаа хөрөнгийг тусгаарлах, өмчлөх эрхийг шилжүүлэх, тусгаарлалтаас чөлөөлөх үйл ажиллагаа дараах процессын дагуу явагдана:
- 5.1.1. зээлдүүлэгч буюу барьцаалагч нь зээлдэгч буюу барьцаалуулагчтай байгуулсан барьцааны гэрээний үндсэн дээр барьцааны мэдэгдлийг хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн сан (цаашид “цахим мэдээллийн сан” гэх)-д бүртгүүлж, баталгаажуулна;
  - 5.1.2. барьцаалагч нь цахим мэдээллийн санд баталгаажсан барьцааны талаарх мэдээллийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ;
  - 5.1.3. үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь барьцаалуулагчийн үнэт цаас тусгаарлуулах хүсэлт, бусад холбогдох баримт материалыг дараах мэдээллүүдийн хамт барьцаалагчаас албан бичгээр авсны дараагаар үнэт цаас тусгаарлах үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:
    - 5.1.3.1. анхны мэдэгдлийн бүртгэлийн дугаар;
    - 5.1.3.2. барьцаалуулагчийн талаарх мэдээлэл:
      - 5.1.3.2.1. Монгол Улсын иргэн бол регистрийн дугаар;
      - 5.1.3.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт буюу түүнтэй адилтгах баримт бичгийн дугаар;
      - 5.1.3.2.3. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, нэр;
    - 3.2.1.3. барьцаанд байршуулах үнэт цаасны тоо ширхэг, нэрлэсэн үнэ, хаалтын ханш.
  - 5.1.4. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь үнэт цаасны тусгаарлалтад бүртгэсэн тухай мэдэгдлийг барьцаалагчид ажлын 3 өдрийн дотор албан бичгээр хүргүүлнэ.
- 5.2. Барьцаалуулагч нь барьцааны мэдэгдлийн бүртгэлийн хугацааг сунгах тухай мэдэгдлийг гаргаагүй бол цахим мэдээллийн санд бүртгүүлснээс хойш гурван жилийн хугацаанд барьцааны мэдэгдлийн бүртгэл хүчинтэй байна.
- 5.3. Энэхүү журмын 5.2-т заасан хугацаанаас өмнө барьцаалуулагч дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон, үүнтэй холбогдуулан шүүхээс барьцааны зүйлийг барьцаалагч этгээдийн эзэмшилд шилжүүлэх шийдвэр гарсан тохиолдолд барьцаалагч нь барьцааны бүртгэлийг цуцлах тухай мэдэгдлийг гурван өдрийн дотор цахим мэдээллийн санд хүргүүлнэ.
- 5.4. Барьцаалагч нь цахим мэдээллийн сангаас баталгаажуулсан барьцаа цуцлагдсан талаарх мэдээллийг 5.3-т дурдагдсан шүүхийн шийдвэрийн хамт Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.
- 5.5. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь энэ журмын 5.4-т заасан баримт материалд үндэслэн барьцаалагчийн холбогдох дансанд өмчлөх эрхийг шилжүүлнэ.
- 5.6. Барьцаалагч болон барьцаалуулагчийн зөвшөөрлөөр барьцааны мэдэгдлийн бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, бүртгэлийн хугацааг сунгах, цуцлах тохиолдолд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан шаардлагын дагуу гаргана.
- 5.7. Цахим мэдээллийн санд баталгаажсан барьцааг үнэт цаасны тусгаарлалтад бүртгэх, тусгаарлалтаас чөлөөлөхтэй холбоотойгоор үүсэх нарийвчилсан харилцааг Үнэт

цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын холбогдох журмаар зохицуулах ба кастодиан нь тус байгууллагын гишүүнчлэлийнхээ хүрээнд дээрх үйл ажиллагааг эрхэлж болно.

## **ЗУРГАА. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

### **6.1. Зээлдүүлэгчийн эрх, үүрэг**

- 6.1.1. Зуучлагчаар дамжуулан үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээнд оролцох тохиолдолд:
  - 6.1.1.1. зээлдүүлсэн үнэт цаасны ногдол ашиг болон үнэт цаасны хүүг хүртэх;
  - 6.1.1.2. талууд гэрээгээр тохиролцсон бол зээлдүүлсэн үнэт цаасыг зээлдэгчээс буцаан дуудах;
  - 6.1.1.3. үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээний шимтгэлийн орлогод ногдох татварыг тайлагнах.
- 6.1.2. Зуучлагчгүйгээр шууд дамжуулан үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээнд оролцох тохиолдолд:
  - 6.1.2.1. дотоод үйл ажиллагаандаа дагаж мөрдөх үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг үзүүлэх тухай нарийвчилсан журамтай байх;
  - 6.1.2.2. үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай шуурхай, тасралтгүй, үйл ажиллагааны онцлогт тохирсон тусгай программ хангамжтай байх;
  - 6.1.2.3. үнэт цаасны барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлж, баталгаажсан барьцааны талаарх мэдээлэл, зээлдэгчийн үнэт цаас тусгаарлуулах хүсэлт болон бусад холбогдох баримт материалыг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад хүргүүлж, зээлдэгчийн барьцаанд тавьсан үнэт цаасыг тусгаарлуулах;
  - 6.1.2.4. зээлийн эрсдэлийг бууруулах, удирдах зорилгоор шаардлагатай барьцаа хөрөнгийн хэмжээг өдөр бүр тооцоолох;
  - 6.1.2.5. барьцаа хөрөнгийн анх байршуулсан хэмжээ шаардлагатай хэмжээнээс бага болсон тохиолдолд зээлдэгчээс нэмэлт барьцаа байршуулахыг шаардах, их болсон тохиолдолд зээлдэгчид барьцааны тодорхой хэсгийг буцаан шилжүүлэх;
  - 6.1.2.6. зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон үед барьцаа хөрөнгийг зарж, эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авах;
  - 6.1.2.7. талууд гэрээгээр тохиролцсон бол зээлдүүлсэн үнэт цаасыг зээлдэгчээс буцаан дуудах;
  - 6.1.2.8. гэрээ дуусгавар болох эсхүл аль нэг талын санаачилгаар цуцлах үед зээлдэгч зээлсэн үнэт цаасыг буцаан шилжүүлсэн тохиолдолд барьцаа хөрөнгийг буцаан олгох;
  - 6.1.2.9. гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд холбогдох байгууллагад тухай бүр мэдэгдэх;
  - 6.1.2.10. арилжаа эрхлэх байгууллагын мэдээллийн платформд зээлдүүлж болох үнэт цаасны мэдээллийг тухай бүр хүргүүлэх;
  - 6.1.2.11. үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээтэй холбоотой мэдээллийг Хороонд хүргүүлэх;

6.1.2.12. үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой гэрээ, заавар, баримт бичиг болон холбогдох бусад бүртгэлийг цахим болон цаасан хэлбэрээр таваас доошгүй жил хадгалах.

### **6.2. Зуучлагчийн эрх, үүрэг**

- 6.2.1. үнэт цаас зээлдүүлэх болон зээлэх хүсэлт гаргасан этгээдтэй гэрээ байгуулахаас өмнө үнэт цаас зээлдүүлэх болон зээлэхтэй холбогдон үүсэж болзошгүй эрсдэлийн тухай мэдээллийг холбогдох талуудад заавал танилцуулах;
- 6.2.2. дотоод үйл ажиллагаандаа дагаж мөрдөх үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг үзүүлэх тухай нарийвчилсан журамтай байх;
- 6.2.3. зээлдүүлэх үнэт цаасыг бүртгэх, хадгалах, талуудыг мэдээллээр хангах, зээлдүүлэгчийн өмнөөс эрх, үүргийг хэрэгжүүлэх;
- 6.2.4. зээлдүүлсэн үнэт цаасны ногдол ашиг болон үнэт цаасны хүүг зээлдэгчээс зээлдүүлэгчид шилжүүлэх;
- 6.2.5. дотоод үйл ажиллагаандаа дагаж мөрдөх үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг үзүүлэх тухай нарийвчилсан журамтай байх;
- 6.2.6. үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай шуурхай, тасралтгүй, үйл ажиллагааны онцлогт тохирсон тусгай программ хангамжтай байх;
- 6.2.7. үнэт цаасны барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлж, баталгаажсан барьцааны талаарх мэдээлэл, зээлдэгчийн үнэт цаас тусгаарлуулах хүсэлт болон бусад холбогдох баримт материалыг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад хүргүүлж, зээлдэгчийн барьцаанд тавьсан үнэт цаасыг тусгаарлуулах;
- 6.2.8. зээлийн эрсдэлийг бууруулах, удирдах зорилгоор шаардлагатай барьцаа хөрөнгийн хэмжээг өдөр бүр тооцоолох;
- 6.2.9. барьцаа хөрөнгийн анх байршуулсан хэмжээ шаардлагатай хэмжээнээс бага болсон тохиолдолд зээлдэгчээс нэмэлт барьцаа байршуулахыг шаардах, их болсон тохиолдолд зээлдэгчид барьцааны тодорхой хэсгийг буцаан шилжүүлэх;
- 6.2.10. зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон үед барьцаа хөрөнгийг зарж, эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авах;
- 6.2.11. гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд холбогдох байгууллагад тухай бүр мэдэгдэх;
- 6.2.12. арилжаа эрхлэх байгууллагын мэдээллийн платформд зээлдүүлж болох үнэт цаасны мэдээллийг тухай бүр хүргүүлэх;
- 6.2.13. үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээтэй холбоотой мэдээллийг Хороонд хүргүүлэх;
- 6.2.14. үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой гэрээ, заавар, баримт бичиг болон холбогдох бусад бүртгэлийг цахим болон цаасан хэлбэрээр таваас доошгүй жил хадгалах.

### **6.3. Зээлдэгчийн эрх, үүрэг**

- 6.3.1. зээлж авсан үнэт цаасыг эргэн төлөх баталгаа болгон зээлдүүлэгчийн шаардсан барьцаа хөрөнгийг гэрээнд заасны дагуу байршуулах;
- 6.3.2. шаардлагатай барьцаа хөрөнгийн хэмжээ анх байршуулсан барьцаа хөрөнгийн ханшнаас буурсан тохиолдолд нэмэлт барьцаа хөрөнгө байршуулах, илүү гарсан

тохиолдолд барьцааны тодорхой хэсгийг буцаан шилжүүлэхийг зээлдүүлэгчээс шаардах;

- 6.3.3. зээлж авсан үнэт цаастай холбоотой ногдол ашиг, хүү, саналын эрх зэрэг эрхийг эдлэх бөгөөд тухайн үнэт цааснаас үүсэх өгөөжийг зээлдүүлэгчид гэрээнд заасан хугацаанд нөхөн олгох;
- 6.3.4. барьцаанд тавьсан үнэт цаасны хүү, ногдол ашгийн орлого болон саналын эрх зэрэг үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх;
- 6.3.5. талуудын харилцан тохиролцсон мэдээллийг зээлдүүлэгчид гаргаж өгөх;
- 6.3.6. гэрээ дуусгавар болох эсхүл аль нэг талын санаачилгаар цуцлах үед зээлж авсан үнэт цаасыг зээлдүүлэгчид буцаан шилжүүлэх;
- 6.3.7. барьцаанд тавьсан үнэт цаасыг давхар барьцаалж ашиглахгүй байх.

#### **6.4. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын эрх, үүрэг**

- 6.4.1. талуудын хооронд байгуулсан гэрээний мэдээлэл болон бусад холбогдох мэдээллийг үндэслэн үнэт цаасны өмчлөх эрхийг аливаа хүндрэл, чирэгдэлгүйгээр шуурхай байдлаар шилжүүлэх;
- 6.4.2. гэрээг дуусгавар болсныг үндэслэн зээлдэгчийн зээлсэн үнэт цаасыг нэр төрөл, тоо ширхгээр зээлдүүлэгчид буцаан шилжүүлэх;
- 6.4.3. барьцаа хөрөнгийг тусгаарлах, чөлөөлөх үйл ажиллагааг гэрээ, мэдээлэлд тулгуурлан гүйцэтгэх.

#### **6.5. Арилжаа эрхлэх байгууллагын эрх, үүрэг**

- 6.5.1. зээлэх, зээлдүүлэх боломжтой үнэт цаасны жагсаалт, мэдээллийг агуулсан цахим платформуор оролцогч талуудыг хангаж, байнгын ажиллагаатай байлгах;
- 6.5.2. зээлэх, зээлдүүлэх үйл ажиллагаа, богино хугацааны зарах хэлцэл (шорт сэлл)-тэй холбоотой системийн бэлэн байдлыг хангаж, техник болон мэдээллийн саадгүй ажиллагааг тасралтгүй хангах;
- 6.5.3. богино хугацааны зарах хэлцэл (шорт сэлл)-тэй холбоотой нарийвчилсан журмыг боловсруулж, Санхүүгийн зохицуулах хороогоор батламжлуулах.

### **ДОЛОО. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ**

7.1. Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээтэй холбоотой дараах мэдээллийг Хороонд цахимаар хүргүүлнэ. Үүнд:

- 7.1.1. үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой оролцогч талууд хооронд байгуулсан гэрээний хуулбар;
- 7.1.2. үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээний хүрээнд хийгдсэн хэлцлийн сар бүрийн мэдээллийг дараа сарын 5-ны дотор;
- 7.1.3. үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой үйлчилгээний шимтгэлийн хувь, түүнд өөрчлөлт орсон бол шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор;
- 7.1.4. зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд холбогдох мэдээллийг тухай бүр;
- 7.1.5. үнэт цаас зээлдүүлэх гэрээтэй холбоотой маргаан шүүх, хяналтын байгууллагад шилжсэн тохиолдолд тухай бүр.